

Фукушимад болж буй үйл явдал: Цөмийн түлшний нэвчилт гэдэг хайлахаасаа ч долоон дор

06/13/2011

Орчуулсан Амарлин

Эх сурвалж: <http://www.shortnews.com/start.cfm?id=89710>

Фукушима дахь байдал улам дордож буй тухай шинэ мэдээнд өгүүлэхдээ АЦС-ын 1,2,3-р реакторууд хэт халснаас цөмийн түлш хайлсан ба түүгээр зогсохгүй бүр гадагш нэвчин урссан байх талтай хэмээжээ.

Хайлах (“meltdown”) гэдэг нь цөмийн түлш хэт халснаар хайлж, реакторын голыг гэмтээхийг хэлдэг бол хайлсан цөмийн түлш реакторын ёроолоор нэвчиж, хөрсөнд шингэхийг нэвчилт (“melt-through”) гэдэг. Цөмийн түлшний нэвчилт нь цөмийн ослын улмаас гарч болох хамгийн золгүй үйл явдалд тооцогддог байна.

Нөхцөл байдал туйлын ноцтой байгаа бөгөөд Японы дээгүүр албан тушаалтан Ичиро Озава гэгч энэхүү нэвчилтийг зогсоох талаар арга хэмжээ авахгүй бол зөвхөн Фукушима төдийгүй нийт Японы газар нутаг дээр хүн амьдрах боломжгүй болох аюултай хэмээн анхааруулжээ.